



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 14



Ажил эрхэлж буй гадаадын иргэд өмнөх улирлаас 2.7 хувиар буурчээ

Манай улсад 2022 оны эхний улирлын байдлаар гадаадын 92 улсын 5.5 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна.


Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.0 (23.2%) мянган хүнээр өсөж, өмнөх улирлаас 154 (2.7%) хүнээр буурсан байна.

Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 4.8 (87.0%) мянга нь эрэгтэй, 0.7 (13.0%) мянга нь эмэгтэй байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаад иргэдийн 56.8 хувь нь БНХАУ-ын, 5.1 хувь нь ОХУ-ын, 4.9 хувь нь БНЭУ-ын, 4.6 хувь нь БНСУ-ын, 3.8 хувь нь АНУ-ын, 3.5 хувь нь Вьетнам Улсын, 3.2 хувь нь Австрали Улсын, 3.0 хувь нь Филиппин Улсын, 15.1 хувь нь бусад улсын харьяат байна.

Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 17.5 хувь нь 50-54 насныхан, 16.9 хувь нь 45-49 насныхан, 14.6 хувь нь 35-39 насныхан байгаа бол 2.5 хувь нь 24 хүртэлх насныхан байна.

Ажил эрхэлж байгаа гадаад иргэдийн 2.0 (36.7%) мянга нь Төвийн бүсэд, 2.0 (36.6%) мянга нь Улаанбаатарт, 0.9 (15.6%) мянга нь Зүүн бүсэд, 0.3 (5.8%) мянга нь Баруун бүсэд, 0.3 (5.3%) мянга нь Хангайн бүсэд ажиллаж байна.

ЗУРАГ 1. АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Ажил эрхэлж байгаа гадаад иргэдийн 2517 (46.1%) нь дипломын болон бакалаврын дээд, 1862 (34.1%) нь техникийн болон мэргэжлийн, 515 (9.4%) нь бүрэн дунд, 401 (7.3%) нь тусгай мэргэжлийн дунд, 134 (2.5%) нь суурь, 34 (0.6%) нь магистр, доктор боловсролтой байна.


Ажил эрхэлдэг гадаад иргэдийн 2.4 (44.1%) мянга нь мэргэжилтэн, 1.2 (22.2%) мянга нь техникч болон туслах дэд мэргэжилтэн, 0.7 (12.2%) мянга нь менежер, 0.6 (10.4%) мянга нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 0.4 (8.0%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, 96 (1.8%) нь энгийн ажил, мэргэжил, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 45 (0.8%) нь контор, үйлчилгээний ажилтан, 27 (0.5%) нь худалдаа, үйлчилгээний болон хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтнаар ажиллаж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар



Манай улсад 2022 оны 1 дүгээр улиралд ажил эрхэлж буй гадаад иргэдийн 1836 (33.6%) нь уул уурхай, олборлолтын, 1106 (20.2%) нь барилгын, 748 (13.7%) нь боловсролын, 539 (9.9%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 365 (6.7%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 310 (5.7%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 191 (3.5%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 117 (2.1%) нь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны, 251 (4.6%) нь бусад салбарт ажиллаж байна. Өмнөх улиралтай харьцуулахад, тухайлбал боловсролын салбарт ажил эрхэлж буй гадаадын иргэд 254 (51.4%) хүнээр өсөж, барилгын салбарт 494 (30.9%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар, улирлаар



Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг ажиллаж буй байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 5.0 (92.2%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.2 (3.3%) мянга нь төрийн бус байгууллагад, 0.3 (4.5%) мянга нь бусад байгууллагад ажиллаж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.

Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах” тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу “HG”, “O” болон “SH” ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.

- “HG” ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.
- “SH” ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.
- “O” ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.



Эх үүсвэр:

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн газар Өрхөд
суурилсан судалгааны хэлтэс
статистикч Б.Лхагвасайхан
Утас : (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212